

Being involved and confident
in learning and play

Family resources

Тоглох болон суралцахдаа өөртөө итгэлтэй байж, идэвхтэй оролцох

Гэр бүлд зориулсан материал

Сургуулийн Өмнөх Боловсролын бодлого (Early Years Learning Framework) нь цэцэрлэг болон бага насны хүүхдэд зориулсан бүх төрлийн үйлчилгээ явуулдаг байгууллагуудын мөрдөх үндэсний хэмжээний боловсролын бодлого юм. Хүүхдийг зорилгот таван чиглэлээр сургаснаар тухайн хүүхэд сурах хатуужил, өндөр чадвартай болоход нь энэхүү бодлогын зорилго юм.

Сургалтын 4-р үр дүн бол хүүхдүүд өөртөө итгэлтэй мөн идэвхитэй суралцагч байх тухай юм. Хүүхдүүд бол судлаач, уялдуулан холбогч, шүүмжлэлтэй сэтгэгч нар бөгөөд сурсан зүйлээ цоо шинэ дүр зураг болгон хувиргах чадвартай. Хүүхдүүд өөрсдийгөө шинжээч, асуудлыг шийдэгч гэж хардаг ба суралцахдаа тэд манлайлагч байж чаддаг. Тэд бүтээлч сэтгэлгээгээ ашиглан юмс хэрхэн, яаж ажилладаг тухай олж мэддэг.

Early Years Learning Framework-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах линкээр орж танилцана уу
<https://www.acecqa.gov.au/nqf/national-law-regulations/approved-learning-frameworks>

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ цэцэрлэг эсвэл бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбогдоорой. Хэрвээ утсаар холбогдоход танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны хүссэн дугаар руу залган мөн тухайн шугамд орчуулагчийг таньтай холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Сургуульд суралцах

Сургуулийн Өмнөх Боловсрол

Ур чадвартай ба идэвхитэй суралцагч гэдэг нь:

Хүүхдүүд хүрээлэн буй орчноо судлахдаа өөрсдийн мэдрэмжүүдээ ашигладаг байна

Хүүхдүүд багаж болон материалыг ашиглан сониуч байж, ажиглалт хийн, зохион бүтээх болон задлах чадвартай байна

Хүүхдүүд тоо, тэмдэгт болон утга санаануудыг өөрөөр дүрслэн үзүүлэх чадвартай байна

Хүүхдүүд туршилт хийх, асуудал шийдэх болон шинэ нөхцөл байдалд хариу үзүүлэхдээ олон төрлийн арга барилыг ашиглаж чаддаг байна

Сурагчид асуулт асуух, таамаглах, төлөвлөх, анализ хийх болон харилцах чадвартай болно (Сэдвүүд: Шинжлэх ухаан ба Технологи, Математик)

Сурагчид хүрээлэн буй орчин дах асуудлуудыг ойлгож, боломжит шийдлүүдийг гаргаж сурна (Сэдэв: Шинжлэх ухаан ба Технологи)

Сурагчид шүүмжлэлтэй болон бүтээлч сэтгэгчид байж чадна (Бүх сэдвийн хүрээнд)

Сурагчид өдөр тутмын хэллэг, бодит баримт, материалуудыг ашиглан мэдлэгээ шалгах боломжтой (Сэдэв: Математик)